



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/66


Арвайхээр

### Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2."а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны "Бүтээлч Өвөрхангай-2020" хөтөлбөрийн 4.1.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах зардалд 45.000.000 (дөчин таван сая) төгрөгийг зарцуулах эрхийг Баян-Өндөр сумын Засаг даргад шилжүүлсүгэй.
2. Автомашин худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг Баян-Өндөр сумын Засаг дарга (Э.Насанцогт)-д даалгасугай.
3. Дээрх зардлыг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100139